

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/110/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 оны 02 дугаар сар	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗӨСҮТ	Зоонозын өвчин судлалын үндэсний төв
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЭМС	Эрүүл мэндийн сайд



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.01.31 № 2/04

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Зоонозын өвчин судлалын төвд 2022 онд ЗӨСҮТ-өөс 96,132.4 мянга, аймгийн Эрүүл мэндийн газраас 10,996.5 мянга, аймгийн Онцгой байдлын комиссоос 1,019.5 мянга, нийт 108,148.4 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй ирснийг бүртгэснээр санхүүгийн тайлангийн бараа материал өмнөх оноос нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

005020110

Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 стратеги зорилтыг хэрэгжүүлэх 78 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Эрүүл мэндийн газраас 87.5 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,922,967.35	150,187,836.56
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	2,465,421.26
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	2,465,421.26
3121	Төгрөг	00.00	2,465,421.26
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,465,421.26
35	БАРАА МАТЕРИАЛ	32,922,967.35	147,722,415.30
351	Түүхий эд материал	22,194,034.74	131,140,052.69
35110	Тусгай зориулалттай материал	11,684,267.00	15,865,767.00
35130	Эм боох материал	10,509,767.74	115,274,285.69
354	Хангамжийн материал	10,728,932.61	16,582,362.61
35410	Бичиг хэргийн материал	2,165,640.00	3,020,950.00
35420	Аж ахуйн материал	5,374,659.09	11,926,354.09
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	54,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,113,033.52	10,758.52
35450	Барилгын засварын материал	518,100.00	863,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,557,500.00	707,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,039,519,154.01	991,944,713.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,039,519,154.01	991,944,713.92
392	Биет хөрөнгө	843,519,154.01	795,944,713.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	784,675,084.33	791,175,084.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-60,204,797.92	-77,301,756.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	100,850,000.00	49,350,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-34,794,166.68	-25,486,666.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	145,414,181.18	154,331,181.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-110,920,749.89	-116,953,271.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,988,238.00	32,093,238.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,197,017.90	-15,530,262.74
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,836,417.80	24,836,417.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,128,034.91	-20,569,250.51
393	Биет бус хөрөнгө	196,000,000.00	196,000,000.00
39301	Програм хангамж	869,000.00	869,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-869,000.00	-869,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	196,000,000.00	196,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,072,442,121.36	1,142,132,550.48
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,145,781.56	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,145,781.56	00.00
413	Өглөг	1,145,781.56	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	556,738.36	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	371,293.20	00.00
4136	Бусад өглөг	217,750.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	67,000.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	150,750.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,071,296,339.80	1,142,132,550.48
51	Засгийн газрын хувь оролцоо	1,071,296,339.80	1,142,132,550.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	427,624,333.39	427,624,333.39
51101	Өмч: - төрийн	427,624,333.39	427,624,333.39
512	Хуримтлагдсан үр дүн	577,191,091.31	648,027,301.99
51210	Өмнөх үеийн үр дүн	577,191,091.31	577,191,091.31
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	70,836,210.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,480,915.10	66,480,915.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,072,442,121.36	1,142,132,550.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	684,501,918.00	671,463,465.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,266,124.00	114,144,865.41
120	Нийтлэг татварын бус орлого	79,266,124.00	114,144,865.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,465,421.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,465,421.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	605,235,794.00	557,318,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	509,439,300.00	553,818,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	509,439,300.00	553,818,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,796,494.00	3,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,752,270.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	86,044,224.00	3,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	644,167,597.59	564,089,754.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	644,167,597.59	564,089,754.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	631,383,500.96	564,085,253.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	351,727,834.40	379,764,996.82
210101	Үндсэн цалин	189,236,503.00	267,437,027.91
210102	Нэмэгдэл	129,161,529.00	78,821,308.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,990,948.80	18,769,260.00
210104	Урамшуулал	21,338,853.60	14,737,400.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,911,672.33	44,522,333.17
210201	Тэтгэврийн даатгал	33,319,566.87	29,754,321.39
210202	Тэтгэмжийн даатгал	5,493,106.75	3,211,094.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,565,370.74	3,922,991.21
210204	Ажилгүйдлийн даатгал	684,657.03	693,847.81
210205	Эрүүл мэндийн даатгал	6,848,970.94	6,940,078.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,128,712.00	35,629,219.58
210301	Гэрэл, цахилгаан	1,714,552.00	2,605,439.58
210302	Түлш, халаалт	31,363,760.00	31,363,760.00
210303	Цэвэр, бохир ус	1,050,400.00	1,660,020.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,069,114.00	29,519,872.08
210401	Бичиг хэрэг	1,460,660.00	3,008,730.00
210402	Тээвэр, шатахуун	15,939,898.00	14,993,920.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,166,956.00	1,952,894.68
210404	Ном, хэвлэл	125,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	113,250.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,263,350.00	8,964,327.40
2105	Нормативт зардал	32,333,916.50	14,199,556.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,719,916.50	13,689,556.20

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,614,000.00	510,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,525,507.00	13,660,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,554,297.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,300,000.00	1,540,600.00
210604	Урсгал засвар	5,671,210.00	12,119,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,928,000.00	8,143,800.00
210702	Дотоод албан томилолт	3,928,000.00	8,143,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,632,127.00	3,148,236.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,015,185.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	170,000.00	170,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,000.00	430,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,512.00	317,836.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	175,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,926,130.00	1,188,900.00
210807	Газрын төлбөр	784,000.00	784,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	45,300.00	82,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,126,617.73	35,496,940.12
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,126,617.73	35,496,940.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,784,096.63	4,500.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	380,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	380,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,404,096.63	4,500.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,404,096.63	4,500.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>40,334,320.41</u>	<u>107,373,710.65</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	36,537,499.97
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	36,537,499.97
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-36,537,499.97
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>40,334,320.41</u>	<u>70,836,210.68</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>605,235,794.00</u>	<u>559,784,021.26</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	2,465,421.26
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	2,465,421.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,465,421.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,465,421.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	605,235,794.00	557,318,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	509,439,300.00	553,818,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	509,439,300.00	553,818,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,796,494.00	3,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,752,270.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	86,044,224.00	3,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>594,865,994.00</u>	<u>535,968,600.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	594,865,994.00	535,968,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	582,081,897.37	535,964,099.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	351,540,768.40	377,855,969.13
210101	Үндсэн цалин	187,789,457.00	246,886,576.42
210102	Нэмэгдэл	129,161,529.00	84,467,762.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,261,172.80	19,522,260.00
210104	Урамшуулал	21,328,609.60	26,979,370.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,460,777.97	46,988,099.22
210201	Тэтгэврийн даатгал	33,540,799.06	31,956,943.14
210202	Тэтгэмжийн даатгал	3,952,748.97	3,474,239.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,537,505.57	3,922,991.21
210204	Ажилгүйдлийн даатгал	675,211.29	693,847.81
210205	Эрүүл мэндийн даатгал	6,754,513.08	6,940,078.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,128,712.00	35,629,219.58
210301	Гэрэл, цахилгаан	1,714,552.00	2,605,439.58
210302	Түлш, халаалт	31,363,760.00	31,363,760.00
210303	Цэвэр, бохир ус	1,050,400.00	1,660,020.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,979,733.00	30,677,000.08
210401	Бичиг хэрэг	1,640,900.00	4,331,990.00

210402	Тээвэр, шатахуун	15,360,307.00	13,841,893.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,186,956.00	1,851,994.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	116,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,675,570.00	10,051,122.40
2105	Нормативт зардал	15,012,600.00	10,888,175.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,522,600.00	7,510,675.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,490,000.00	3,377,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,322,757.00	22,502,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,894,997.00	7,315,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,333,300.00	1,906,000.00
210604	Урсгал засвар	5,094,460.00	13,281,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,928,000.00	8,143,800.00
210702	Дотоод албан томилолт	3,928,000.00	8,143,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,708,549.00	3,279,136.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,972,537.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	170,000.00	170,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,000.00	430,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,512.00	317,836.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	175,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,050,000.00	1,319,800.00
210807	Газрын төлбөр	784,000.00	784,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	40,500.00	82,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,784,096.63	4,500.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	380,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	380,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,404,096.63	4,500.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,404,096.63	4,500.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>10,369,800.00</u>	<u>23,815,421.26</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,369,800.00	21,350,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,369,800.00	21,350,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,369,800.00	21,350,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,369,800.00	21,350,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-10,369,800.00</u>	<u>-21,350,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	2,465,421.26
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,465,421.26

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,483,487.00	566,590,678.72	1,060,698,499.11
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,624,333.39	66,483,487.00	566,590,678.72	1,060,698,499.11
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-28,404,979.71	-28,404,979.71
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,480,915.10	577,191,091.31	1,071,296,339.80
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,480,915.10	577,191,091.31	1,071,296,339.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,624,333.39	66,480,915.10	577,191,091.31	1,071,296,339.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	70,836,210.68	70,836,210.68
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,480,915.10	648,027,301.99	1,142,132,550.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	553,818,600.00	553,814,099.21	4,500.79	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	553,818,600.00	553,814,099.21	4,500.79	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	553,818,600.00	553,814,099.21	4,500.79	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377,856,000.00	377,855,969.13	30.87	100.0
210101	Үндсэн цалин	249,071,800.00	246,886,576.42	2,185,223.58	99.1
210102	Нэмэгдэл	81,707,800.00	84,467,762.70	(2,759,962.70)	103.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,097,000.00	19,522,260.00	574,740.00	97.1
210104	Урамшуулал	26,979,400.00	26,979,370.01	29.99	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,988,100.00	46,988,099.22	0.78	100.0
210201	Тэтгэврийн даатгал	30,267,500.00	31,956,943.14	(1,689,443.14)	105.6
210202	Тэтгэмжийн даатгал	3,930,200.00	3,474,239.02	455,960.98	88.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,144,100.00	3,922,991.21	221,108.79	94.7
210204	Ажилгүйдлийн даатгал	786,000.00	693,847.81	92,152.19	88.3
210205	Эрүүл мэндийн даатгал	7,860,300.00	6,940,078.04	920,221.96	88.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,629,400.00	35,629,219.58	180.42	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,605,500.00	2,605,439.58	60.42	100.0
210302	Түлш, халаалт	31,363,800.00	31,363,760.00	40.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,660,100.00	1,660,020.00	80.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	32,147,100.00	32,147,000.08	99.92	100.0
210401	Бичиг хэрэг	3,932,400.00	4,331,990.00	(399,590.00)	110.2
210402	Тээвэр, шатахуун	14,405,800.00	12,261,893.00	2,143,907.00	85.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,903,200.00	1,851,994.68	1,051,205.32	63.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,288,000.00	3,650,000.00	(1,362,000.00)	159.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,617,700.00	10,051,122.40	(1,433,422.40)	116.6
2105	Нормативт зардал	10,888,200.00	10,888,175.20	24.80	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,510,700.00	7,510,675.20	24.80	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,377,500.00	3,377,500.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,803,400.00	40,802,700.00	700.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,115,000.00	19,115,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,906,700.00	1,906,000.00	700.00	100.0
210604	Урсгал засвар	19,781,700.00	19,781,700.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	6,227,200.00	6,223,800.00	3,400.00	99.9
210702	Дотоод албан томилолт	6,227,200.00	6,223,800.00	3,400.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,279,200.00	3,279,136.00	64.00	100.0

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	170,000.00	170,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	430,000.00	430,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	317,900.00	317,836.00	64.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	175,000.00	175,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,319,800.00	1,319,800.00	-	100.0
210807	Газрын төлбөр	784,000.00	784,000.00	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	82,500.00	82,500.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	553,818,600.00	553,814,099.21	4,500.79	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	553,818,600.00	553,814,099.21	4,500.79	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	553,818,600.00	553,814,099.21	4,500.79	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,465,421.26		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	25.00	3.00	89.3
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	25.00	3.00	89.3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29.00	26.00	3.00	89.7
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.00	21.00	(2.00)	110.5
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	05.00	5.00	50.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,500,000.00
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,500,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь "Ёс зүй хариуцлага, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах" эрхэм зорилготой, 2022 онд "Байгууллагын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, сурч хөгжих таатай орчныг бүрдүүлэн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх" зорилго дэвшүүлэн, тус зорилтын хүрээнд дараах 3 зорилтыг хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнд:

1. Ажлын байрны таатай орчин бүрдүүлэх
2. Ажлын байрны тасралтгүй сургалтыг зохион байгуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах
3. Албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангаж, тогтвортой ажиллах орчинг бүрдүүлэх

Тус байгууллага нь Эрүүл мэндийн яам, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, аймгийн Эрүүл мэндийн газраас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч 21, төрийн үйлчилгээний бусад албан хаагч 5, нийт 26 орон тоотой үйл ажиллагаа явуулжээ.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Б.Алтанчимэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Одонтуяа нар зурж, нярваар Ч.Отгонтөгс ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, НББ-ийн тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Эрүүл мэндийн тухай, Дархлаажуулалтын тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын багц, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Архивын тухай хуулиудыг мөрдөж, үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн;
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн;
- Байгууллага, байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээнд өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2021 онд гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69,690.4 мянган төгрөгөөр буюу 64.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	2,465.4	2,465.4
Авлага	-	-	-
Бараа материал	32,923.0	147,722.4	114,799.4
Үндсэн хөрөнгө	1,277,632.9	1,248,654.9	(28,978.0)
Хуримтлагдсан элэгдэл	(238,113.8)	(256,710.2)	(18,596.4)
Нийт хөрөнгө	1,072,442.1	1,142,132.6	69,690.4
Өр төлбөр	1,145.8	-	(1,145.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,071,296.3	1,142,132.6	70,836.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,072,442.1	1,142,132.6	69,690.4

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн залруулагдсан санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Ахмадын сангийн журмыг 2019.01.15-ны өдөр баталж, оны эцэст 2,465.4 мянган төгрөгийг Төрийн сангийн 100030020501 тоот дансанд байршуулснаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байхад санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залруулсан.

ЗӨСҮТ-өөс 2022 оны 6, 11 дүгээр сард 96,132.4 мянган төгрөгийн автомакс, 10,0 мянган ширхэг 95,640.0 мянган төгрөгийн бараа материал, аймгийн Онцгой байдлын комиссоос 1,019.2 мянган төгрөгийн бараа материал, аймгийн Эрүүл мэндийн газраас 10,996.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй олгосноос бараа материалын данс өмнөх оноос 114,789.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/25 дугаар тогтоолоор 12,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2400-БНХ улсын дугаартай пажеро маркын суудлын автомашиныг Богд сумын ИТХ-д балансаас баланст шилжүүлж, мөн өдрийн 9/26 дугаар тогтоолоор Засаг даргын нөөц хөрөнгөөс 2021.10.05-ны өдөр худалдан авсан 39,500.0 мянган төгрөгийн Toyota hiace маркийн автомашиныг аймгийн ОНӨГ-т шилжүүлэх шийдвэр гарсныг хэрэгжүүлэн ажилласан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/25 дугаар тогтоолоор 1,900.0 мянган төгрөгийн 2 хөрөнгийг акталж, тоног төхөөрөмжөөс хасагдсан нь үндсэн хөрөнгө буурах шалтгаан болжээ.

Оны эхэнд 1,145.8 мянган төгрөгийн өглөгтэй байсныг тайланд хугацаанд барагдуулан, оны эцэст өглөггүй ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 70,836.2 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,142,132.6 мянган төгрөг болсон байна.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төв улсын төсвөөс авах санхүүжилт санхүүжилт өмнөх оноос 44,379.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 553,818.6 мянган төгрөг болсон ба санхүүжилтийг бүрэн авч, үйл ажиллагаандаа батлагдсан төсвийн 99.9 хувь буюу 553,814.1 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 4.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ. Өмнөх оноос төсөв нэмэгдсэн нь цалингийн зардал, урсгал засварын зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 70,836.2 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,142,132.6 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 677,671.4 мянган төгрөг авахаар төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 182,362.7 мянган төгрөгөөр бууруулж, 495,308.7 мянган төгрөгөөр баталсан нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс ихэнх урсгал зардлуудыг хасаж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2022 оны 6 дугаар сард Эрүүл мэндийн сайдын А/309 дүгээр тушаалаар 38,609.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 533,818.6 мянган төгрөгөөр баталсан ба 11 дүгээр сард 2022.03.24-ний өдөр аймгийн Мэргэжлийн хяналтын газраас тус байгууллагын дулаан алдалт болон өнгө үзэмж муудаж нурах

аюултай гэсэн дүгнэлт гаргасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэн төсөвт тодотгол хийх саналыг хүргүүлэн төсвийг нэмж 20,000.0 мянган төгрөгөөр тодотгон, нийт 553,818.6 мянган төгрөгийг баталжээ. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71601 (нийгмийн эрүүл мэнд) хөтөлбөрийн 80101 (үндсэн үйл ажиллагааны зардал), 80802 (ажил олгогчоос олгох тэтгэмж) арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс, 553,818.6 мянган төгрөгийг олгохоор байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс батлагдсан санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 553,814.1 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 4.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ХӨТӨЛБӨР 71601-НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД				
1.1	АРГА ХЭМЖЭЭ 80101 -Үндсэн үйл ажиллагааны зардал	553,818.6	553,814.1	4.5	99.9%
1.2	АРГА ХЭМЖЭЭ 80102-Ажил олгогчоос тэтгэмж	0	0	0	0
	Дүн	553,818.6	553,814.1	4.5	99.9%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн батлагдсан төсвийн хуваарь

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗӨСҮТ-өөс 2022 оны 8 дугаар сард 3,500.0 мянган төгрөгийн нэмэлт төсвийг олгож, ЗӨСҮТ-ийн захирлын 2022.08.19-ний өдрийн А-42 дугаар тушаалын дагуу “Халдвараас сэргийлэх хяналтыг чадавхжуулах” сэдэвт сургалт зохион байгуулахад зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд тухайн байгууллагад төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн бараа материалын тайланг хянаж зардлыг нягтлан бодох бүртгэлд тухай бүр тусгах, үндсэн хөрөнгийн ашиглах жилийг НБББББ-т заасны дагуу үнэн зөв бүртгэх, хөрөнгийн тооллогын дүнг хэлэлцэх, ТАЦНС-д нийгмийн даатгалын хувийг үнэн зөв бүртгэх, хоолны мөнгийг зохих хууль, тогтоомжийн дагуу олгох зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 553,818.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,307.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,815.1 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага ЗӨСҮТ, аймгийн ЭМГ-аас ирүүлсэн чиглэлийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 553,818.6 мянган төгрөгийн 12 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 4,496.6 мянган төгрөгийн 5 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 23,890.9 мянган төгрөгийн 3 гүйлгээ, тайлант онд бусад аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн 11 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, 737.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 4,955.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч, менежментийн захидлаар 2 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	737,327	2	737,327	100
Албан шаардлага	2	4,955,740	2	4,955,740	100
Зөвлөмж	2	-	2	-	100
Нийт дүн	6	5,693,067	6	5,693,067	-

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2022.05.09-ний өдрийн 69 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна. Аудитаар хэрэгжилтийг тооцож, шийдвэрийн хэрэгжилтийг тооцож ажилласан болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЗӨСҮТ-өөс 2022 оны 12 дугаар сард нэг бүр нь 9.5 мянган төгрөгийн үнэ бүхий 10,000 ширхэг, 95,640.0 мянган төгрөгийн нүдний шил үнэ төлбөргүй ирж, Улаанбаатар хотоос Баянхонгор аймаг руу тээвэрлэх замын зардалд 1,200.0 мянган төгрөгийг зарцуулсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Шалгагдагч байгууллагаас жилд 1,000 ширхэг шилийг хэрэглэхэд 10 жилийн нөөцийг нийлүүлсэн гэж мэдэгдэж байгаа тул цаашид ЗӨСҮТ-өөс бараа

материалын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, санал авсны дагуу нийлүүлэх шаардлагатай байна. Энэ асуудлыг ЗӨСҮТ-ийн санхүүгийн тайланд тодруулан авч үзэх нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,817.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. "НИК" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу тайлант онд тус байгууллагад 352.4 мянган төгрөгийн шатахууны хөнгөлөлт олгож, үүнээс 342.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, 9.5 мянган төгрөгийн шатахуун картад үлдэгдлээр байхад нягтлан бодогч бараа материалын орлого, зарлагаар бүртгээгүй байна.

2. Байгууллагын дарга тушаал гараагүй атлаа оны эцэст цалингийн хэмнэгдсэн зардлаас тайлант онд батлагдсан цалингийн зардлын 0.65 хувиар буюу 2,465.4 мянган төгрөгийг Төрийн сангийн 10030020501 дансанд шилжүүлж, зардлаар тайлагнаж санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнаагүй байна.

Аудитаар нийт 34,080.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 168.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 33,912.2 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын төсвийн захирагч дээд газрын эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр нэг өдрийн хоолны мөнгийг 5.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн, тайлант оны 11-12 дугаар сард нийт 168.2 мянган төгрөгийг олгосон байгаа нь ЭМС-ийн 2018.12.28-ны өдрийн А/548 дугаар тушаалыг зөрчсөн тул төсвийн захирагчаар нөхөн төлүүлэн, орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын даргын 2022.06.15-ны өдрийн А/20, 2022.12.30-ны өдрийн А/48 дугаар тушаалаар 2,969.3 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг актлахдаа устгасан баримт үйлдээгүй, жилийн эцэст эд хөрөнгийн тооллогын комисс тооллогын дүнг буруу гаргасан, хөрөнгийн нэрсийг дутуу бичсэн, өмч хамгаалах зөвлөлийн тайланд хөрөнгийн дүн зөрүүтэй байхад байгууллагын нягтлан бодогч тооцоо бодоогүй, байгууллагын дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно”, 71 дүгээр зүйлийн 71.1 дэх “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана: 2/ бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх”, 73 дугаар зүйлийн 73.2 дахь “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг хэрэгжүүлэн хөрөнгийг устгасан тухай актыг үйлдэж, баримтад хавсаргах, нягтлан бодогчийн ажлын хариуцлагыг сайжруулж, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан зааврын НХМ БМ-7 маягтаар тооцоо бодож, түүнд даргаас тавих хяналтыг сайжруулах

2. Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2013 онд оны 55.0 мянган төгрөгийн бикс, 2011 оны 540.0 мянган төгрөгийн зургийн аппарат зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанаргүй хөрөнгийг бүртгэж, ашиглах жилийг 0 жилээр бүртгэсэн, 2022 онд худалдан авсан 2,349.0 мянган төгрөгийн үнэ бүхий Canon mg 244 маркийн канон принтерийн ашиглах жилийг хасах 1 жилээр бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2010 оны 388 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.37 дахь заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг санхүүгийн программд зөв бүртгэх

3. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: ТАЦНС-д ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 12,5 хувиар тооцсон байхад нийгмийн даатгалын НД-7, 8 мэдээгээр тус хувийг 13,5 хувиар тооцсон ба үүнээс шалтгаан тайлант онд ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал хүрээгүй тул цалингийн зардлаас 4,178,243 төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж: ТАЦНС-д ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн хувийг хуульд нийцүүлэн албан хаагч тус бүрээр үнэн зөв оруулах

4. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хамтын гэрээнд 2022 онд өөрчлөлт оруулан хоолны мөнгийг өдөрт 5000 төгрөгөөр нэмэгдүүлэн 8.0 мянган төгрөг болгон, байгууллагын даргын 2022.11.23-ны өдрийн А/37 дугаар тушаалаар баталж, 11-12 дугаар саруудын батлагдсан төсвөөс 3,914.0 мянган төгрөгийн хоолны мөнгө илүү олгосон, мөн албан томилолтоор ажилласан ажилтнуудад тухайн хугацаанд хоолны мөнгийг давхардуулан 258,0 мянган төгрөгийг олгосон, томилолтын мөнгө олгохдоо байгууллагын дарга тушаал гаргаагүй байгаа нь ЭМС-ийн 2018.12.28-ны өдрийн А/548 дугаар тушаал, Сангийн сайдын 2022.06.02-ны өдрийн 120 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ЭМС-ийн 2018.12.28-ны өдрийн А/548 дугаар тушаал, батлагдсан төсвийн хүрээнд хоолны мөнгийг олгох, Сангийн сайдын 2022.06.02-ны өдрийн 120 дугаар тушаалын 1 дэх заалтыг мөрдөж, томилолтоор ажилласан хугацааны хоолны зардал, хоолны мөнгийг давхардуулан олгохгүй байх.

5. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Түүврийн аргаар нярвын бэлтгэсэн шатахууны тайланг санхүүгийн программын бүртгэлтэй тулган шалгахад тайланг нягтлан бодогч хянадаггүй, нярвын зарцуулалтыг нягтлан бодогч сар бүр нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын нярвын бэлтгэсэн бараа материалын тайланг хянан шалгаж, тухай бүрд санхүүгийн программд үнэн зөв оруулж, нягтлан бодогч ажлын хариуцлагаа дээшлүүлэх

6. Нийцлийн холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээших 23,890,940 төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, мэдээллийг байгууллагын цахим хуудаст тухай бүр байршуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
"НИК" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу тайлант онд тус байгууллагад 352.437.48 төгрөгийн шатахууны хөнгөлөлт олгосноос 342,926.48 төгрөгийн шатахуун зарцуулсныг нярвын тайланд тайлагнасан, 9,511 төгрөгийн шатахуун картад үлдэгдлээр байхад нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.	1	352.4	1	352.4			1	352.4				
Байгууллагын дарга тушаал гараагүй атлаа тайлант онд батлагдсан цалингийн зардлын 0.65 хувиар буюу 2,465,421.26 төгрөгийг оны эцэст Төрийн сангийн 10030020501 дансанд шилжүүлсэн байхад санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тусгаагүй байна.	1	2465.4			1	2465.4	1	2465.4				
Дүн	2	2817.8	1	352.4	1	2465.4	2	2817.8	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн захирагч дээд газрын эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр ЭМС-ийн 2018.12.28-ны өдрийн А/548 дугаар тушаалаар баталсан нэг өдрийн хоолны мөнгийг хэтрүүлэн авсан байна.	1	162.8	1	162.8								
Байгууллагын даргын 2022.06.15-ны өдрийн А/20, 2022.12.30-ны өдрийн А/48 дугаар тушаалаар 2,969.3 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг актлахдаа устгасан баримт үйлдээгүй, жилийн эцэст эд хөрөнгийн тооллогын комисс тооллогын дүнг буруу гаргасан, хөрөнгийн нэрсийг дутуу бичсэн, өмч хамгаалах зөвлөлийн тайланд хөрөнгийн дүн зөрүүтэй байхад байгууллагын нягтлан бодогч тооцоо бодоогүй, байгууллагын дарга хяналт тавьж ажиллаагүй байна.	1	2,969.30					1	2,969.30				
Үндсэн хөрөнгөд 2013 оны 55.0 мянган төгрөгийн бикс, 2011 оны 540.0 мянган төгрөгийн зургийн аппарат зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанаргүй хөрөнгийг бүртгэж, ашиглах жилийг 0 жилээр бүртгэсэн, 2022 онд худалдан авсан 2,349.0 мянган төгрөгийн үнэ бүхий Canon mg 244 маркийн канон принтерийн ашиглах жилийг хасах 1 жилээр бүртгэсэн байна.	1	2,944.00					1	2,944.00				
ТАЦНС-д ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 12,5 хувиар тооцсон байхад нийгмийн даатгалын НД-7, 8 мэдээгээр тус хувийг 13,5 хувиар тооцсон ба, үүнээс шалтгаан тайлант онд ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн	1	0					1	0				

зардал хүрээгүй тул цалингийн зардлаас 4,178.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.												
Тайлант оны 11 дүгээр сард хамтын гэрээнд өөрчлөлт оруулан хоолны мөнгийг өдөрт 5000 төгрөгөөр нэмэгдүүлэн, 11-12 дугаар саруудын батлагдсан төсвөөс 3,914.0 мянган төгрөгийг илүү олгосон, томилолтын зардлыг хоолны мөнгөтэй давхардуулан олгосноос 258.0 мянган төгрөгийн томилолтыг илүү олгосон, томилолтын мөнгө, хоолны мөнгийг нэмэгдүүлэн олгохдоо байгууллагын дарга тушаал гаргаагүй байгаа	1	4,108.0					1	4,108.0				
Түүврийн аргаар нярвын бэлтгэсэн шатахууны тайланг санхүүгийн программын бүртгэлтэй тулган шалгахад нярвын бэлтгэсэн шатахууны тайланг нягтлан бодогч хянадаггүй, нярвын зарцуулалтыг нягтлан бодогч сар бүр нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.	1	0					1	0				
Дүн	6	10,189.5	1	162.8	0	0	5	10,021.3	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээших 23,890.9 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.	1	23,890.9						1	23,890.9
Дүн	1	23,890.9	0	0	0	0	0	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	1	23,890.9	0	0	0	0	0	1	0

---oOo---